## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ХОРООНЫ 2014 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| д/д | Төлөвлөсөн ажил | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|
| 1 | Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албан хаагчийн эрмэлзэх 9 зүйл, Төрийн захиргааны албан хаагчийн ёс дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдол бүхий эрх зүйн баримт бичгийг судлуулах, мөрдүүлэх ажил зохион байгуулж, төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх, цуврал сургалт явуулах | Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага, ур чадвар, төрөөс баримтлах аялал жуулчлалын бодлого, үйл ажиллагааг нийслэл орон нутагт хэрэгжүүлэх асуудлаар сургалт, мэдээлэл, ярилцлагыг мэргэжилтэн, албан хаагчдаа оролцуулан 6 удаа зохион байгуулсан, Төрийн албан хаагчдыг ажил мэргэжлийнх нь чиглэлийн сургалт, зөвлөгөөн, арга зүйн хуралд давхардсан тоогоор 25 удаагийн үйл ажиллагаанд суралцуулсан | 100% |
| 2 | Байгууллагын хэмжээнд ёс зүйн хэм хэмжээг тогтоохоор 2014 онд "Ёс зүйг эрхэмлэнэ" зорилт дэвшүүлж, байгууллагын хамгийн сайн төрийн албан хаагчийг шалгаруулах | Энэ ажлын хүрээнд ямар нэг зөрчил гараагүй бөгөөд тэргүүний албан хаагчийг тодруулсан. | 100% |
| 3 | Байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчийн ёс зүй, харилцаатай холбогдол бүхий гомдол, мэдээллийг хүлээн авч хянан шийдвэрлэж, иргэд, аж ахуйн нэгжид хариу мэдээлж байх | Төрийн албан хаагчид нь холбогдох дүрэм, журмыг баримтлан ажиллаж, Ёс зүйн зөрчил гаргаагүй болно | 100% |
| 4 | Ёс зүйн асуудлаар хийж буй ажил, ёс зүйн зөрчлийн талаархи мэдээ, тайланг журмын дагуу цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж Нийслэлийн Ёс зүйн хороонд хүргүүлэх | Тогтоосон хугацаанд нь гаргаж мэдээ тайлан 2 удаа хүргүүлсэн. | 100% |
| 5 | Төрийн албан хаагчдыг хариуцсан ажил, мэргэжлийн холбогдолтой өдөр тутам ашиглаж байх тулгуур хууль, эрх зүйн баримт бичиг, захирамж, тушаалын жагсаалт гаргуулан мөрдүүлж ажиллах | Төрийн албан хаагчдыг өдөр тутам гарын авлага болгон ашиглах, мөрдөх хууль эрх зүйн лавлагаа сангаа шинэчлэн ажиллаж хэвшсэн | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | Албан хаагчдын хууль эрх зүй, ёс зүй, албан хэрэг хөтлөлтийн талаархи мэдлэгийг дээшлүүлэх сорилт, тестийн шалгалт авах, албан хаагчдын дунд гарч болзошгүй нийтлэг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх урамшуулалт хэлэлцүүлэг, ярилцлага хийх | Сургалт ярилцлагын үеэр хэлэлцүүлэг ярилцлага хийсэн. Үүнд мэргэжилтнүүд идэвхтэй оролцож, санал сэтгэгдлээ ярилцав. Мөн байгууллагын архив, албан хэргийн мэдлэгийн тест асуулга авсан. | 100% |
| 7 | “Төрийн албан хаагчийн эрмэлзэх 9 зүйл”-ийн хэрэгжилтийг хангуулах | Байгууллагын Ёс зүйн хорооноос төрийн захиргааны шинэ залуу албан хаагчиддаа Монгол улсын Төрийн албан хаагчдын эрмэлзэх есөн зүйлийг танилцуулж , байгууллагын ёс зүйн дүрмийг баримтлан ажиллахыг тогтмол зөвлөллөө, ялангуяа цагийн бүтээлийг дээшлүүлэх, цаг баримтлахад анхаарч ажиллахыг зөвлөв. | 98% |
| 10 | Албан хаагчдын нийгмийн асуудал, ажил, амьдрал ахуйд нь тулгарч байгаа асуудлаар чин сэтгэлийн уулзалт хийж, байгууллагаас хууль, журмын хүрээнд дэм туслалцаа үзүүлэх | Төрсөн өдөр, эмнэлэгт эмчүүлэхэд хамт олны дэм туслалцааг үзүүлж, бие чийрэгжүүлэх ажлуудыг зохион байгуулсан | 100% |
| 12 | Ёс зүйн хорооноос хийсэн ажлын тайлан, төлөвлөгөө, мэдээ судалгаа, хурлын тэмдэглэл гэх мэт бичиг баримтын хавтас нээн, баяжилт хийж, архивын сан хөмрөг үүсгэн ажиллах | Бичиг баримтын бүрдүүлэлт хийсэн | 100% |
| 13 | Ёс зүйн хорооноос хийж буй ажил, цаашид хийх ажлаа байгууллагын удирдлагад танилцуулж, зөвлөмж авч байх. ажлын уялдаа холбоог сайжруулах | Байгууллагын удирдлагад танилцуулж, 3 удаагийн зөвлөмж авч ажилласан байгаа | 100% |
| Нийт дүн | | | 100% |

Танилцсан:
Дарга Э.Баттулга

УОА0453

Тайлан гаргасан:
Мэргэжилтэн: М.Баасандорж